



**EURASIA CAPITAL
HOLDING JSC**

**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 4-р сарын 30

Улаанбаатар хот

“Евразия капитал холдинг ҮЦК” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4-р сарын 30 өдөр 12 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Худалдааны гудамж, Дельта төв 5-р давхар, 502 тоот өрөөнд өрөөнд эхлэв.

Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч нийт ирцийг тооллогын комисст хүлээлгэн өгөв.

Энэхүү хуралд компанийн хувьцаа эзэмшигчид болох “Мезза Файнэншл Групп” ХХК, “Омега Инвест” ХХК, “Вистекс Глобал Инвест” ХХК-ийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нар оролцсон бөгөөд нийт 2 197 018 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 2 270 892 ширхэг энгийн хувьцааны 96.7% болж хурал хүчин төгөлдөр эхлэв.

Хурлын дарга Г.Халиунаа:

- Хурлыг нээж, хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:
 - Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 - Компанийн 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 - Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
 - Нэмэлт хувьцаа гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх
 - Ногдол ашиг хувиарлахгүй тухай тайлагнах
 - Бусад.

Хурлаар хэлэлцэх асуудлаа нэг бүрчлэн авч хэлэлцээд тухай бүрд нь асууж тодруулах зүйлээ асууя гэсэн саналтай байна. Та бүхэн юу гэж бодож байна?

Хуралд оролцогчид:

- Зөвшөөрч байна.

Хурлын дарга Г.Халиунаа:

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх тайланг та бүхэнд тараасан байгаа, мөн компанийн 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болох бизнес төлөвлөгөөг хэвлэн тараасан байгаа. Асуух зүйл байвал асуугаарай.

Хуралд оролцогчид:

- Зөвшөөрч байна. Асуух зүйл алга.

Хурлын дарга Г.Халиунаа:

Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах тухай компанийн хувьцаа эзэмшигч "Мезза Файнэншл Групп" ХХК-ийн захирал Камолиддин Талипов танилцуулна.

Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Тус компани нээлттэй хувьцаат компанийн хувьд үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулахад Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах шаардлагатай байгаа тул хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг таван тэрбум хүртэл төгрөгөөр нэмэгдүүлэх саналтай байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхдээ олон нийтэд болон хаалттай хүрээнд, стратегийн хөрөнгө оруулагчдад нэр заан эзэмшүүлэхээр таван тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гарган уг шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулъя. Хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгох нь зөв гэж үзэж байна. Бид дахин хөрөнгө оруулалт хийх сангуудтай холбогдон нааштай үр дүнд хүрээд байна.

Бид нэмэлт хувьцаа гаргаснаар хувьцааныхаа төвлөрлийг бууруулах мөн үйл ажиллагаагаа явуулах эрхээ сэргээлгэх, хэвийн явуулах ач холбогдолтой. Компанийн хувьцааны тоо ширхэг нэмэгдэж байгаа нь компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл болж дүрмийн шинэчилсэн найруулгыг бэлтгэн та бүхэнд танилцуулж байна. Дараагийн асуудал болох өрийг хувьцаагаар солих асуудал байгаа. Манай компани бусдад өгөх өр төлбөр ихтэй байгаа. Өрийг хувьцаагаар солих хүсэлтэй байгаа хувьцаа эзэмшигчидтэй тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсны дараа шийдвэрлэх эрхийг ТУЗ-д өгөх саналтай байна. Өрийг хувьцаагаар солих нь компанид ч дарамтгүй зөв шийдвэр гэж бодож байна.

Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчид:

- Зөвшөөрч байна.

"Омега Инвест" ХХК компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Саидаброр Рустамходжаев:
Нэмж хувьцаа гаргах зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрсний дараа шаардах эрхийн хүрээнд нэгж хувьцааг худалдаж авах үнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоосон үнээр эргүүлэн худалдан авах нь зөв байх. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргахтай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэх саналтай байна. Тус компани нь ашигтай ажиллаагүй тул ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэх саналтай байна.

Хувьцаа эзэмшигчид:

- Асуух зүйл байхгүй. Дэмжиж байна. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийг шинээр томилогдох ТУЗ болон ТУЗ-ийн даргад үүрэг болгох саналтай байна.

Зөв зөв. Дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигчдийн санал хүсэлтийн дараа саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсний дараа хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

“Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна” хэмээн Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга Х.Мөнгөнцэцэг танилцууллаа.

“Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн 2024 оны 4 сарын30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлын дагуу **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталж 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав.
2. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлав.
3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргах, тусгай зөвшөөрлийг сэргээхийг даалгав.
4. Өрийг хувьцаагаар солих асуудлыг зөвшөөрөв.
5. Тэргүүн ээлжинд хувьцаа эзэмшүүлэхгүй байхаар шийдвэрлэв.

Хурлын дарга Г.Халиунаа хурлыг хаав.

Хурал: 13 цаг 55 минутад өндөрлөв

Тэмдэглэл хөтөлсөн:

Хянасан:

Хурлын дарга:

А.Амирлан

Г.Халиунаа

